

МОНГОЛ ДАХЬ БАНКНЫ КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

Судалгааны хэлтсийн эдийн засагч А. Хулан

Өнөө үед дэлхий нийтээр бэлэн мөнгөний төлбөр тооцооноос бэлэн бус төлбөр тооцоо, тэр дундаас электрон төлбөр тооцоонд эрчимтэйгээр шилжиж байна. Төлбөр тооцоо бол эдийн засгийн нэг ёсны хөдөлгүүр, зайлшгүй дэд бүтэц юм. Баялаг үйлдвэрлэгч болон түүний хэрэглэгчийг холбож өгдөг, найдвартай, түргэн шуурхай төлбөр тооцооны систем бол эдийн засгийн хөгжлийг түргэсгэх чухал түлхүүр болно. Электрон төлбөр тооцоо буюу бэлэн бус төлбөр тооцооны системийн сайн талуудыг дурьдвал, нийт эдийн засгийн хэмжээнд бэлэн мөнгөтэй харьцах шаардлагыг багасган, тэр хэмжээгээр бэлэн мөнгөөр хийх төлбөр тооцооны давхар зардлуудыг хэмнэж, үргүй зардлыг багасгаж үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааны банкуудын татан төвлөрүүлэх хөрөнгийг нэмэгдүүлж, тэр хэрээр зээлийн эх үүсвэр нэмэгдэн, хөрөнгө оруулалт ихэсч, банк санхүүгийн үйлчилгээг хэрэглэдэггүй хүмүүсийг банкны системд татаж оруулах, сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааг албан ёсны эдийн засагт шилжүүлэх, санхүүгийн хяналтыг сайжруулах зэргээр үргэжлэнэ. Түүнчлэн төлбөр тооцоог хөнгөн шуурхай гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийг бэлэн мөнгөний эрсдэлээс хамгаалж, олон төрлийн нэмэлт үйлчилгээнд хамрагдаж, цаг, мөнгөө хэмнэх, өөрийн санхүүг зохицуулан удирдахад дөхөм болох юм.

Нийт 50 улсуудыг харьцуулсан судалгаанаас харахад эдийн засаг дахь нийт төлбөр тооцоонд бэлэн бус төлбөр тооцооны эзлэх жинг 10 хувиар нэмэгдүүлэхэд ДНБ-ий өсөлт 0.5 нэгжээр нэмэгдэнэ гэсэн тооцоо гарсан байна¹. /Visa. 2004/.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг анх 1950 онд Дайнерс Клуб компани гаргаж, 1958 онд Американ Экспресс, 1966 онд Виза болон МастерКарт компаниуд удаалжээ. Анхны эдгээр карт нь одоогийн бидний мэддэг шиг банкны данстай шууд холбоотой бус харин зээлийн карт буюу кредит карт байсан байна. 1970-аад оны дундуур Виза болон МастерКарт компаниуд банкны данстай шууд холбоотой карт буюу дебит карт гаргасан ч өргөн хэрэглээг олоогүй явсаар 1990-ээд онтой золгосон түүхтэй. Харин энэ үеэс бэлэн бус төлбөр тооцоо огцом өсч эхэлжээ.

¹ Visa. *Payment solutions for modernising economies*. 2004


1999 оны 2 дугаар улиралд Голомт банк Мастер карт гаргаснаар олон улсын сүлжээнд холбогдсон бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картын үйлчилгээ Монголд нэвтэрчээ. Түүний дараагаар Худалдаа Хөгжлийн Банк, Анод банкууд удаалж, одоогийн байдлаар нийт 9 арилжааны банк төлбөр тооцооны картын үйлчилгээ үзүүлж байна.

Дэлхий нийтээр төлбөр тооцоог бэлэн мөнгөөр хийх нь багасч картын төлбөрийн хэрэглээнд шилжиж байгаа өнөө үед манай улсад картын хэрэглээний хөгжил, картын зах зээлийн цар хүрээ ямар байгааг судлах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

1. Картын төрлүүд болон карт эзэмшигчийн тоо

Нийт карт эзэмшигчдийн тоо 1999 онд 758 байсан бол жилээс жилд хурдацтайгаар өсч 2005 оны эцсийн байдлаар 241.0² мянгад хүрчээ. Үүний дотроос идэвхтэй карт эзэмшигч³ нь 2005 оны эцэст 178.2 мянга /73.9 хувь/ байгаа бөгөөд сүүлийн 2 жилийн дунджаар нийт хэрэглэгчийн 71.2 хувь нь идэвхтэй хэрэглэгч байсан байна. Энэ нь нийт картын 26.1 хувь буюу дөрөвний нэг орчим нь бэлэн бус төлбөр тооцоо, мөнгө бэлнээр авах, дансанд хийхэд огт хэрэглэгддэггүй буюу хэрэглээнд ордоггүй, эсвэл хэрэглэх хугацаа нь дуусчихсан картууд байна гэсэн үг юм.

Зураг 1. Картын хэрэглээний өсөлт



Карт эзэмшигчдийн тоогоор Голомт банк бусдыгаа тэргүүлж, 2005 оны эцсийн байдлаар нийт банкны картын зах зээлийн 52.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 2 жилийн дунджаар авч үзвэл карт эзэмшигчдийн тоо улиралд 11.7 хувиар буюу сард 4 орчим хувиар өсч байгаа юм. Эхний үед зөвхөн Голомт банк картын үйлчилгээ үзүүлдэг байсан бол 2001 оны 4 дүгээр улиралд Худалдаа Хөгжлийн Банк болон Анод банк картын үйлчилгээ нэвтрүүлснээр картын тоо тухайн үед 80.7 хувиар огцом

² Картын дансаа хаалгасан, картаа банкиндаа буцааж өгсөн иргэдийг оруулаагүй. Харин картын хүчинтэй хугацаа нь хэтэрсэн боловч дансаа хаалгаагүй иргэд/байгууллагуудыг оруулж тооцсон.

³ Сүүлийн 1 жилд дор хаяж 1 удаа бэлэн бус төлбөр тооцоо эсвэл мөнгө бэлнээр авах, хийхэд өөрийн картаа ашигласан нь идэвхтэй хэрэглэгч болно.

өссөнийг 2 дугаар зургаас харж болно. Үүний дараагийн томоохон өөрчлөлт бол Голомт банк 2003 оны 3 дугаар улиралд оюутны карт хэрэглээнд оруулснаар картын өсөлт тухайн улиралд 89.5 хувьд хүрсэнийг харж болно.

Зураг 2. Картын тоо



Картын төрлүүд нь хэрэглээний болон хэрэглэгчийн онцлогоос шалтгаалан 30 хүртэлх төрөл байна.

Нийт картын 47.4 хувь нь Олон Улсын МастерКарт /MasterCard International/ компанийн картын сүлжээнд холбогдсон, 49.0 хувь нь Олон Улсын Виза /Visa International/ компанийн сүлжээнд холбогдсон карт байна⁴. 3.5 хувь нь Анод банкны өөрийн сүлжээний □Цахим□ карт байгаа юм.

Виза, Мастеркарт картын төрлүүд нь тогтсон байдаг тул манай арилжааны банкуудын гаргасан картууд нь дотооддоо болон олон улсад хэрэглэгдэх дебит, кредит эрхтэй энгийн, алтан, оюутны, байгууллагын болон бизнес карт гэсэн ерөнхий төрлүүдтэй байна. Дебит картаар хийгдсэн гүйлгээний дээр хэмжээ нь холбогдох дансны үлдэгдэлээр хязгаарлагддаг бол кредит карт нь тухайн банкнаас зээлжих эрхтэй карт гэдгээрээ түүнээс ялгаатай.

2005 оны эцсийн байдлаар 241.0 мянган карт хэрэглээнд байгаагаас 20.9 хувь нь буюу 50.3 мянган карт /зээлийн эрхтэй⁵ байна. Эдгээр нь гол төлөв тухайн хэрэглэгчийн гүйлгээний түүхийн судалгаан дээр үндэслэгдэж өгөгддөг, тодорхой дээд хязгаартай, хадгаламж, харилцахын дүн болон цалингаар баталгааждаг, сарын эцэст зээлийн дүнг бүтнээр нь төлөх, эсвэл сар болгон урьдчилан тогтоосон хэмжээг төлөх зэрэг хэлбэртэй байна.

⁴ Карт авсан байгаад дансаа хаалгаж, картаа буцаасан Голомт банкны хэрэглэгчдийг оруулж тооцсон. Эдгээр нь нийт хэрэглэгчдийн 0.5% болно.

⁵ Хадгаламж, харилцах болон бусад барьцаа хөрөнгө шаардагддаг, зээлийн дүнг хэрэглэгчийн данс руу шилжүүлдэг г.м. үзүүлэлтийн улмаас эдгээр картыг зээлийн эрхтэй гэхээс бус кредит карт гэж томьёлж болохгүй юм.

Энгийн буюу классик карт нь хямд нөхцөлтэй, элсэлтийн хураамж авдаггүй, үйлчилгээний хураамж болон заавал байлгах доод үлдэгдэл нь бага байдаг тул дундаж түвшний хэрэглэгчдэд илүү тохиромжтой. Цаашилбал энгийн карт нь цалингийн, бензиний, энгийн гэх мэт төрлүүдтэй байдаг байна. Алтан карт нь энгийн карттай ижил боловч үйлчилгээний хураамж, заавал байх үлдэгдэл, нэг өдөр, нэг сард хийгдэх гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар болон бэлэн мөнгөний эрх нь өндөр, дунджаас дээгүүр орлого, нэр хүндтэй хэрэглэгчид болон банкны сайн харилцагчдад зориулагддаг байна.

Бизнес болон байгууллагын карт нь байгууллагын нэрийн өмнөөс хийгдэх төлбөр тооцоог гүйцэтгэх, байгууллагын санхүүгийн баримтыг баталгаатай, найдвартай баримтжуулах, хувь хүмүүсийн албан хэрэгцээний төлбөр тооцоог картын хэрэглээгээр цэгцлэх, хөнгөвчлөх, өөрийн зардлаа хянан эргэлтийн хөрөнгө, бараа материалын нийлүүлэлтээ удирдах зэрэг ач холбогдолтой юм.

Оюутны картын хувьд оюутан сурагчид эзэмшиж, гэрээт байгууллагуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлүүлэх эрхтэй карт юм.

Хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа нь одоогийн байдлаар энгийн карт /46 хувь/ байгаа бөгөөд оюутны карт⁶ тоогоороо удаалж байгаа юм /31 хувь/. Байгууллагын болон бизнесийн картууд нь нийт картын 18 хувь, Алтан карт 5 хувийг эзэлж байна.

Зураг 3. Картын гол төрлүүд



Үйлчилгээний нөхцлүүдийг дурьдахад, банкуудын картын сарын дундаж үлдэгдэлд бодох сарын хүү дунджаар төгрөгийн 0.3 % - 0.5 %, долларын 0.1 % - 0.3 % байна. Картнаас бэлэн мөнгө авах тохиолдолд банкууд өөрсдийн гаргасан картын хувьд шимтгэлгүй үйлчилдэг, бусад картад мөнгөн дүнгийн 0.3 % - 3 % -ийн шимтгэлтэй (дотоодын карт 0.3 %, гадаадын 1 - 3 %) үйлчилдэг.

Манай картын зах зээлд одоогоор төлбөр тооцооны 3 сүлжээ байгаагаас Голомт банкны сүлжээнд Зоос, Капитрон, Хаан, Хас банкууд, Худалдаа Хөгжлийн Банкны сүлжээнд Монгол Шуудан, Хадгаламж банкууд нэгдэж, Анод банк өөрсдийн

⁶ Оюутны картыг 2005 оны эцсийн байдлаар зөвхөн Голомт банк гаргаж байв.

төлбөрийн сүлжээтэй байна. Карт эзэмшигчид нь сүлжээ доторх банкуудын карт уншигч болон бэлэн мөнгөний машиныг ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой. 2002 оны 6 дугаар сараас эхлэсэн Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн Санхүүгийн Чадавхийг Хөгжүүлэх төслийг Монголбанк болон Монгол Улсын Сангийн Яамтай хамтран хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд банк хоорондын электрон төлбөр тооцоог өдөртөө гүйцэтгэж, худалдааны цэгүүд дэх ПОС машиныг уншиж мэдээллийг дамжуулах ТТТ /Төлбөр тооцооны төв/ байгуулснаар дээрх 3 сүлжээний карт эзэмшигчид карт гаргасан аль ч банктай нэг картаар харилцах боломжтой болох, мөн банкууд хөрөнгө оруулалтын зардлаа хувааж төлөх, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх, ингэснээр нэг картын өртөгийг багасгах боломжтой болох юм.

2. Бэлэн бус гүйлгээ

Бэлэн бус төлбөр тооцоо хийхэд хэрэглэгдэх карт уншигч буюу ПОС машины (POS terminal - point of sales terminal) хэрэглээг судалж үзэхэд нийт 1342 ширхэг ПОС машин манай худалдаа үйлчилгээний газруудад хэрэглэгдэж байна. Энэ нь манай улсын хувьд 2005 оны эцсийн байдлаар 1 сая хүн тутамд 530 ПОС машин ногдож байна гэсэн үг бөгөөд хөгжингүй орнуудын 1999 оны түвшинтэй харьцуулахад бараг 20 дахин бага тоо юм. /Хүснэгт 1./

Хүснэгт 1. ПОС машин болон картын тоо.


| Улс | 1 сая хүн тутам дахь ПОС машины тоо | | 1 иргэнд ногдох ПОС гүйлгээний тоо /жилд/ | | 1000 иргэнд ногдох картын тоо |
|---------------|--|-------------|--|-------------|-------------------------------------|
| | 1995 | 1999 | 1995 | 1999 | 1999 |
| Бельги | 7174 | 9767 | 20.8 | 38.6 | 1308 |
| Канад | 6448 | 13278 | 13.4 | 54.3 | 2027 |
| Франц | 9394 | 13529 | 32.3 | 41.3 | 636 |
| Германи | 856 | 3658 | 1.8 | 5.2 | 1200 |
| Итали | 2683 | 7542 | 2.1 | 8.1 | 369 |
| Япон | 200 | - | 0.007 | 0.003 | 2388 |
| Нидерланд | 4736 | 9186 | 16.5 | 44.2 | 1527 |
| Швед | 6160 | 9155 | 10.4 | 26 | 830 |
| Швейцар | 3499 | 8602 | 8.0 | 19.1 | 1106 |
| Их Британи | 8647 | 11765 | - | - | 1881 |
| АНУ | 2010 | 8604 | 6.1 | 27.5 | 2658 |
| Дундаж | 4710 | 9509 | 11 | 26 | 1448 |
| | | 2005 | | 2005 | 2005 |
| Монгол * | | 530 | | 0.77 | 95.1 |

Эх сурвалж: BIS, Statistics on payment systems in G-10 countries, 2001

* Эх сурвалж: Карт, ПОС болон гүйлгээний тоо - энэ судалгааны 2005 оны дүн; Хүн амын тоо - ҮСГ-аас эрхлэн гаргадаг Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2004.

Манай картын систем нь Голомтын, Худалдаа Хөгжлийн Банкны, Анод банкны гэсэн нийт 3 сүлжээнд хуваагдсан байдгаас аль нэг сүлжээний банкны картаар нөгөө сүлжээний машиныг ашиглан төлбөр хийх боломжгүй тул энэ нь нэг ПОС машины үр ашгийг багасгаж байна.

Зураг 4. ПОС машины тоо



Дунджаар үзэхэд 1 ПОС-оор улиралд 351 удаа гүйлгээ хийгдэж нийт 21.7 сая төгрөгийн гүйлгээ явагддаг байна. Нэг удаагийн гүйлгээнд дунджаар 66700 төгрөгийн шилжүүлэг хийгддэг тоо гарч байгаагаас харахад ихэнхдээ томоохон худалдан авалтад карт ашиглагддаг нь харагдаж байгаа юм.

1 карт эзэмшигч улиралд 1.9 удаа л ПОС машин хэрэглэдэг буюу худалдан авалтад картаа ашигладаг гэсэн тоо гарч байгаа нь карт хэрэглэгчдийн дийлэнхи хувь нь ПОС машиныг огт хэрэглэдэггүйг илэрхийлнэ. Үүнийг хүн амтай харьцуулахад 1 иргэний 1 жилд хийх бэлэн бус төлбөр тооцооны тоо 0.72 байгаа нь хөгжингүй орнуудын 1999 оны түвшинтэй харьцуулахад 36 дахин бага байгаа нь мөн чамлалттай тоо юм. /Хүснэгт 1-ийг үзнэ үү./

Банкны картын хэрэглээг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болж буй үйлчилгээний нэг нь бэлэн мөнгөний машин буюу АТМ машин юм. Бэлэн мөнгөний машиныг хэрэглэснээр 24 цагийн турш хэрэглэгч картын данснаас мөнгө авах, үлдэгдлээ шалгах, урьдчилсан төлбөрт карт худалдаж авах гэх мэт үйлчилгээг авах боломжтой болохоос гадна бэлэн мөнгөний үйлчилгээний цэг нэмэгдэж, заавал банк руу очих шаардлагагүй болсноор хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг нэмэгдүүлж байгаа юм. АТМ машин нь хэрэглэгч өөрөө өөртөө үйлчлэх хэлбэртэй тул банкны хувьд ч бичиг цаасны зардал, хүн хүчний нөөцөө хэмнэж, тэр хэрээр зардалаа багасгах боломжтой гэсэн үг.

Одоогийн байдлаар Худалдаа Хөгжлийн Банкны нийт 25 АТМ машин үйлчилгээнд хэрэглэгдэж байна. Эдгээр АТМ машиныг ХХБ-аас гадна Хадгаламж банк, Монгол Шуудан банкны⁷ картын хэрэглэгчид хэрэглэх боломжтой. 2005 оны эцсийн байдлаар 1 сая хүн тутамд 10 АТМ машин оногдож байгаа нь хөгжингүй орнуудын 1999 оны түвшинтэй харьцуулахад даруй 30-100 дахин бага тоо гэдэг нь 2 дугаар хүснэгтээс харагдана.

Хүснэгт 2. АТМ, түүний хэрэглээ

⁷ Хадгаламж, Монгол Шуудан банкны хэрэглэгчид АТМ хэрэглэсний төлбөрт гүйлгээний дүнгийн 0.1 – 0.3%-ийн шимтгэл төлнө.

| | 1 сая хүн тутам дахь АТМ болон бусад бэлэн мөнгө олгох төхөөрөмжийн тоо | | 1 иргэнд ногдох гүйлгээний тоо /жилд/ | | 1000 иргэнд ногдох картын тоо |
|---------------|--|--------------|--|-------------|-------------------------------------|
| | 1995 | 1999 | 1995 | 1999 | 1999 |
| Бельги | 360 | 608 | 14.3 | 17.4 | 1308 |
| Канад | 600 | 874 | 43.7 | 53.4 | 2027 |
| Франц | 395 | 549 | 15.8 | - | 636 |
| Германи | 436 | 562 | 13.4 | 18.4 | 1200 |
| Итали | 378 | 523 | 5.8 | 8.6 | 369 |
| Япон | 1013 | 1143 | 3.8 | 6.0 | 2388 |
| Нидерланд | 378 | 423 | 23.2 | 33.4 | 1527 |
| Швед | 267 | 291 | 31.8 | 35.0 | 830 |
| Швейцар | 532 | 655 | 10.0 | 12.2 | 1106 |
| Их Британи | 358 | 476 | 25.2 | 33.1 | 1881 |
| АНУ | 466 | 831 | 36.9 | 39.9 | 2658 |
| Дундаж | 471.2 | 630.5 | 20.4 | 25.7 | 1448.2 |
| | | 2005 | | 2005 | 2005 |
| Монгол * | | 9.9 | | 0.5 | 95.1 |

Эх сурвалж: BIS, Statistics on payment systems in G-10 countries, 2001

* Эх сурвалж: Карт, ПОС болон гүйлгээний тоо - энэ судалгааны 2005 оны дүн; Хүн амын тоо - ҮСГ-аас эрхлэн гаргадаг Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2004.

2005 оны эцсийн байдлаар үзэхэд 1 улиралд 1 АТМ машинаар 12307 удаагийн гүйлгээ явагдаж, нийт 602.3 сая төгрөг иргэдийн гар дээр олгогдож, 1 гүйлгээ тутамд дунжаар 48900 төгрөгийн гүйлгээ оногдож байна. Дээрх 3 банкны нийт карт хэрэглэгчийн тоогоор авч үзэхэд 1 хэрэглэгч улиралд дунджаар 5.0 удаа АТМ хэрэглэдэг гэсэн тоо гарснаас харахад АТМ машиныг огт хэрэглэдэггүй хэрэглэгч маш олон байгаа нь харагдаж байна.

АТМ нь бэлэн мөнгө олгогч машин тул үүнийг хувь хүн гол төлөв хэрэглэдэг бол ПОС машиныг хувь хүнээс гадна албан байгууллага, компаниуд ч хэрэглэдэг. 1 хэрэглэгч тутамд ногдох АТМ машины хэрэглээ /5.0/ ПОС машины хэрэглээнээс /1.9/ их байгаагаас гадна АТМ хэрэглэх боломжтой Худалдаа Хөгжлийн Банк, Монгол Шуудан, Хадгаламж банкны нийт бэлэн бус гүйлгээний дүнгээс харахад /Зураг 5./ ПОС-ын гүйлгээ 19 хувь, АТМ-ийн гүйлгээ 81 хувийг эзэлж байна. Энэ бүхнээс харахад ПОС машин хэрэглэж гүйлгээ хийдэггүй ч АТМ хэрэглэж данснаасаа бэлэн мөнгө авдаг карт эзэмшигч олон байгааг харуулна.

Зураг 5. Нийт бэлэн бус гүйлгээнд эзлэх АТМ машины гүйлгээний хувь⁸


⁸ АТМ эзэмшигч Худалдаа Хөгжлийн Банк болон АТМ-ийг хэрэглэх боломжтой Хадгаламж, Монгол Шуудан банкны нийт бэлэн бус гүйлгээг үзүүлэв.



Карт эзэмшигчдийн тоогоор 3 дахин бага хэдий ч АТМ болон ПОС машинаар хийгдэх нийт бэлэн бус гүйлгээгээр үзвэл Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банкны хэмжээ ойролцоо байгаагаас харахад ч АТМ машины хэрэглээ бэлэн бус гүйлгээнд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь илэрхий байна. /Зураг 6./ Үүний учир нь АТМ машины үйлчилгээ нь ПОС машины үйлчилгээг бодоход илүү хэрэглэхэд амархан, түргэн шуурхай, найдвартай байдагтай холбоотой болов уу. Манай карт эзэмшигчдийн хувьд АТМ машины хэрэглээг сурах нь бэлэн бус гүйлгээнд шилжих эхний алхам байж ч болох юм.

Харин сүлжээгээр нь ялгаж үзэхэд улиралд нэг хүнд ногдох ПОС-ын хэрэглээ Голомт банкны сүлжээний хувьд 2.46, Худалдаа Хөгжлийн Банкны сүлжээний хувьд 0.82 байгаагаас үзвэл АТМ машины хэрэглээ нь бэлэн бусаар худалдан авалт хийх буюу ПОС машин ашиглалтыг бууруулдаг байж магадгүй харагдана. Нөгөө талаас, ПОС терминал болон АТМ-ы хэрэглээ үйлчилгээний хувьд адилхан түргэн шуурхай, баталгаатай байхад энэ ялгаа буурч ч болох юм.

Зураг 6. Нийт бэлэн бус гүйлгээний дүн⁹




⁹ Зурагт бэлэн бус гүйлгээний мэдээлэл нь өгөгдөөгүй банкуудыг оруулаагүй болно.

Ямар ч байсан хоёр банкны хувьд ПОС машины тоо ойролцоо байгаа боловч ПОС-ын гүйлгээ нь харилцан адилгүй байгаа тул ПОС машины тооноос гадна нийт карт эзэмшигчдийн тоо нь ПОС машины үр ашигтай хэрэглээнд чухал байна. /Зураг 4, 5, 6-г үзнэ үү./

3. Мөнгөний нийлүүлэлт¹⁰

1995 оноос хойшхи мөнгөний нийлүүлэлтийн графикаас харахад 2000 оны дунд үе хүртэл мөнгөний нийлүүлэлт өсч буй /42 тэрбумаас 144 тэрбум төгрөг болов/хэдий ч төгрөгийн харилцахын түвшин өсөөгүй буюу 20-25 тэрбум төгрөгийн орчимд хэлбэлзэж байв. /7-р зураг/. Энэ нь 1996, 1998 оны банкны хямралуудаас үүдэн иргэдийн банкинд итгэх итгэл алдарсантай холбоотой. Тухайн үед мөнгөний өсөлтийг банкнаас гадуурхи бэлэн мөнгөний өсөлт хангаж байв.

Зураг 7. Мөнгөний нийлүүлэлт M1



Банкнаас гадуурхи мөнгө болон мөнгөний нийлүүлэлтийн харьцааны зургаас /8-р зураг/ төгрөгийн харилцах дансад байршуулсан мөнгөний хэмжээ 1995 онд мөнгөний нийлүүлэлтийн /M1/ 40.0 хувийг бүрдүүлж байсан боловч буурсаар 2000 оны 2 дугаар улиралд 17.3 хувьд буюу хамгийн доод түвшиндээ хүрснийг харж болно. Харин энэ үеэс харилцах дансанд байршуулсан мөнгөний хэмжээ өсч 2005 оны 4 дүгээр улирал гэхэд 43.4 хувьд хүрчээ. Энэ нь иргэдийн банкинд итгэх итгэл сэргэж, түүнчлэн банкны үйлчилгээ сайжирч байгаагийн илрэл болж байна.

Зураг 8. Банкнаас гадуурхи мөнгөний M1 мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь

¹⁰ M1 мөнгөний нийлүүлэлтийг авч үзлээ. Энэ нь банкнаас гадуурхи бэлэн мөнгө, банкууд дахь харилцах дансны дүнгээс бүрднэ. Карт нь харилцах данстай гол төлөв холбоотой байдаг /Анод банкны хувьд карт нь гол төлөв хадгаламжийн данстай холбоотой байна/ тул нийт мөнгөний нийлүүлэлт M2-оос илүүтэйгээр картын хөгжлийг харуулах үзүүлэлт болох юм.



Гэвч үүнийг хөгжингүй орнуудтай харьцуулахад манай улсын банкжилтын¹¹ хэмжээ тэдний 1983 оны түвшинд ч хүрээгүй байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 3. Банкнаас гадуурхи мөнгөний харьцаа болон бэлэн бус гүйлгээний тоо

| Улс | Банкнаас гадуурхи мөнгөний М1 мөнгөд эзлэх хувь /%/ | | | Нэг хүнд ногдох бэлэн бус гүйлгээний тоо /1 жилд/ | |
|---------------|---|-------------|-------------|---|--------------|
| | 1983 | 1993 | 1999 | 1983 | 1993 |
| Швейцар | 35 | 34 | 15.1 | - | 67 |
| Нидерланд | 33 | 25 | 13.2 | 85 | 146 |
| Бельги | 41 | 30 | 20.4 | 35 | 101 |
| Итали | 15 | 16 | 15.2 | 13 | 29 |
| Швед | 10 | 9 | 10.6 | - | 93 |
| Норвеги | 33 | 10 | - | - | 97 |
| Герман | 23 | 20 | 23.4 | 86 | 139 |
| Франц | 17 | 15 | 13.2 | 88 | 157 |
| Англи | 26 | 8 | 4.6 | 74 | 115 |
| Финлянд | 26 | 7 | - | 83 | 120 |
| Япон | 25 | 27 | 24.8 | 19 | 39 |
| Канад | 29 | 20 | 16.6 | 88 | 128 |
| Дундаж | 26.1 | 18.4 | 15.7 | 63.4 | 102.6 |
| | 1995 | 2000 | 2005 | | 2005 |
| Монгол* | 60.0 | 77.0 | 56.6 | | 0.5 |

Эх сурвалж: BIS, Statistics on payment systems in the group of 10 countries for 1993, 2001

* Эх сурвалж: Карт, ПОС болон гүйлгээний тоо - энэ судалгааны 2005 оны дүн; Хүн амын тоо - ҮСГ-аас эрхлэн гаргадаг Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2004.

¹¹ Бэлэн мөнгийг банкны дансны хэлбэрээр дахин эргэлтэд оруулсан байдал.

3. Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд манай банк санхүүгийн салбар эрчимтэйгээр хөгжиж байгаа хэдий ч иргэдийн гар дээр бэлэн мөнгө их хэмжээгээр /M1 мөнгөний нийлүүлэлтийн 56.6 хувь/ байршиж байна. Энэ нь хөгжингүй орнуудтай харьцуулахад даруй 40 нэгжээр их тоо юм. Ийм тохиолдолд эдийн засгийн хэмжээнд бэлэн мөнгөтэй харьцах үргүй зардал болон эрсдэл их гардаг.

Манай улсад бэлэн бус төлбөр тооцооны карт эзэмшигчийн тоо хурдацтайгаар өсч, 1999 онд 758 хэрэглэгчтэй байсан бол 2005 оны эцсийн байдлаар нийт 241.0 мянган хэрэглэгчтэй болсон байна. Сүүлийн 2 жилийн дунжаар үзвэл карт хэрэглэгчийн тоо сард 4 хувиар өсч байгаа юм. Гэсэн хэдий ч 1000 хүн тутамд оногдох картын тоо 95.1 байгаа нь хөгжингүй орнуудын 1999 оны түвшинтэй харьцуулахад даруй 15 дахин бага байгаагаас харахад манайд картын зах зээл тэлэх багтаамж их байгааг харуулна. /1 дүгээр хүснэгтийг үзнэ үү./ Түүнчлэн 241.0 мянган карт эзэмшигчээс 26.1 хувь буюу дөрөвний нэг орчим нь картаа огт хэрэглэдэггүй /сүүлийн 1 жилд огт хэрэглээгүй/, эсвэл картын хугацаа нь дуусч хэрэглэх боломжгүй болсон иргэд байна. Иймээс идэвхтэй хэрэглэгчийн тоо /жилд дор хаяж 1 удаа бэлэн бус гүйлгээ хийдэг/ 178.2 мянга байгаа юм.

Бэлэн мөнгийг тун ойрхон орлох чадвартай картыг иргэд хэрэглэж заншсанаар тэдний гар дээрх бэлэн мөнгө банкны дансны хэлбэрт шилжиж, банкуудын зээлийн эх үүсвэр болон хөрөнгө оруулалт нэмэгдэж, иргэд бэлэн мөнгөний эрсдэлээс хамгаалагдаж, нийт эдийн засгийн хэмжээнд үргүй зардал хэмнэгдэж, бүтээмж дээшилдэг гэдэг нь өнөө үед тодорхой болжээ. Нийт бэлэн бус гүйлгээний дүнг үзвэл нэг карт эзэмшигч улиралд 193.5 мянган төгрөгийн гүйлгээ хийдэг гэсэн тоо гарч байна. Энэ нь карт хэрэглэгч бүр багаар бодоход тэр хэмжээний мөнгийг харилцах дансны хэлбэрээр банкинд байршуулж, банкуудад хөрөнгийн эх үүсвэрийг олгож байна гэсэн үг юм.

Худалдаа үйлчилгээний цэгүүд дээр байрлуулсан 1342 ширхэг ПОС машин /POS - point of sale terminal/, бэлэн мөнгө олгох 25 АТМ машин, түүнчлэн банкуудын төв болон салбарууд дээр иргэд картаар үйлчлүүлж гүйлгээ хийх боломжтой. Одоогийн байдлаар 1 хэрэглэгч улиралд дунджаар 1.9 удаа ПОС машинаар гүйлгээ хийж, 5.0 удаа АТМ машин ашиглан бэлэн мөнгө авдаг байна. Энэ нь картын зах зээлд оруулж байгаа карт гаргагч банкуудын хөрөнгө оруулалттай харьцуулахад тун чамлалттай үзүүлэлт юм. Тоног төхөөрөмжийн хувьд нэг АТМ машин 20000-80000 ам. доллар, нэг ПОС машин 400-800 ам. долларын үнэтэй байгаагаас үзвэл банкууд картын зах зээлд хэр хэмжээний их хөрөнгө оруулалт хийсэн нь тодорхой. Харин үүнийг хөгжингүй орнуудын дундажтай харьцуулахад ПОС машины тоо 15-20 дахин бага, АТМ машины тоо 30-100 дахин бага байгаа юм.

Манай улсын хувьд карт эзэмшигчдийн бэлэн мөнгөний машин буюу АТМ машины хэрэглээ нь ПОС машины хэрэглээнээс их байгаагаас, иргэд гол төлөв цалингаа бэлнээр авах хэлбэрээр картыг ашигладаг гэсэн дүгнэлтэд хүрч болно¹². Энэ 1 талаас АТМ машины хэрэглээ нь бэлэн мөнгө авах гэсэн хэрэглэгчийн цагийг хэмнэж, харин ПОС машинаар гүйлгээ хийх нь бэлэн мөнгөөр худалдан авалт хийхтэй харьцуулахад илүү цаг зарцуулж байгаатай холбоотой байж болох юм. Нөгөө талаас АТМ машины

¹² АТМ машин хэрэглэдэг Худалдаа Хөгжлийн Банк, Монгол Шуудан, Хадгаламж банкны хэрэглэгчдийн гүйлгээний хэмжээ болон гүйлгээний тоог авч үзсэн.

хэрэглээг сурах нь манай иргэдийн бэлэн бус гүйлгээнд шилжих эхний алхам байж ч болох юм.

Хөгжингүй орнуудын 1999 оны дунджаар үзэхэд 1 иргэнд ногдох ПОС машины гүйлгээ жилд 26, АТМ машины гүйлгээ жилд 25.7 байхад манай улсын 1 иргэнд ногдох ПОС машины гүйлгээ жилд 0.72, АТМ машины гүйлгээ жилд 0.5 байгаа нь манай картын зах зээлийн хувьд хийж хэрэгжүүлэх зүйлс маш их байгааг харуулж байна. Картын зах зээлийг эрчимтэйгээр хөгжүүлэхийн тулд хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх болон карт хэрэглэх дэд бүтцийг сайжруулж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх зэрэг ажлуудад анхаарлаа зэрэг хандуулах нь зүйтэй юм. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх тусам нэгж тоног төхөөрөмжийн зардал буурч, картын хэрэглээний зардал буурна. Харин картын хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд түүнд ашиглагдах дэд бүтцийг сайжруулж, карт уншигч тоног төхөөрөмжүүдийг хэрэглэгчдэд аль болох ойрхон байлгах буюу тоо хэмжээг нь ихэсгэх хэрэгтэй болно. Картын хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний нэг нь картын хэрэглээний урамшуулал буюу ХХБ банкны явуулж буй гүйлгээний дүнгийн 0.3%-ийн хөнгөлөлт болно. Бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэхэд засгийн газрын үүрэг ч их юм. Засгийн газар нь өөрийн бүхий л үйл ажиллагаанд картыг хэрэглэж, карт хэрэглэхийг дэмжихээс эхлээд картын системийн дэд бүтцэд хийх хөрөнгө оруулалтыг дэмжих, хууль эрхийн орчинг сайжруулах зэрэг алхамуудыг дурьдаж болох юм.

Bibliography

Visa. *Payment solutions for modernising economies*. 2004

BIS. *Statistics on payment systems in G-10 countries, 1994, 1999*.